



Хагас жилийн тайлан



**“МИК Холдинг” ХК-ийн 2018 оны хагас жилийн  
үйл ажиллагааны тайлан**



## Агуулга

<b>1. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>3</b>
1.1 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт.....	4
<b>2. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>5</b>
2.1 Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт .....	5
2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) .....	5
2.3 Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) .....	5
2.3.1 ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүн.....	5
2.3.2 ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг.....	6
2.4 Гүйцэтгэх удирдлага.....	7
2.5 Компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл .....	7
<b>3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>8</b>
3.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр .....	8
3.2 Нөлөө бүхий Хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл.....	8
<b>4. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>8</b>
<b>5. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>8</b>



## 1. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

МИК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган дотоод, гадаад хөрөнгийн зах зээл дээр борлуулах замаар ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх зорилготой бөгөөд “МИК Холдинг” ХК, “МИК ОССК” ХХК болон түүний охин компани болох хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор үүсгэн байгуулагдсан 16 тусгай зориулалтын компаниудаас (ТЗК) бүрдэн үйл ажиллагаагаа явуулж байна.

“МИК Холдинг” ХК нь хувьцаагаа нийтэд нээлттэй арилжаалдаг Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй 1-р ангиллын компани бөгөөд 2015 онд “МИК ОССК” ХХК-ийн хувьцаа эзэмшигчид “Хувьцаа солилцох болон эрх шилжүүлэх гэрээ”-ний дагуу “МИК Холдинг” ХХК-д зохих хувьцааг шилжүүлэн, “МИК Холдинг” ХХК-ийг толгой компани болгон өөрчлөн байгуулснаар “МИК ОССК” ХХК-ийн хувьцааг эзэмшин, удирдлагаар хангах үйл ажиллагааг явуулдаг.

### Компаний эрхэм зорилго

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган дотоод, гадаадын хөрөнгийн зах зээл дээр борлуулах замаар ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, Монгол Улсын хүн амыг орон сууцаар хангах, цаашид орчин үеийн хот байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн урт хугацаат санхүүжилтийн тогтолцоог бий болгож төлөвшүүлэхэд оршдог.

### Компаний зээлжих зэрэглэл

<b>STANDARD &amp; POOR'S</b>	<b>MOODY'S</b>	<b>Fitch Ratings</b>
<b>B-</b>	<b>B3</b>	<b>B-</b>

### Компаний түүх

- 2006 онд Монголбанк, арилжааны 10 банк хувь нийлүүлэн үүсгэн байгуулсан.
- 2012 онд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авч, “Орон сууцны санхүүжилтийн компани” (ОССК) болсон.
- 2015 онд хувьцаагаа нээлттэй хүрээнд арилжаалж Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн том анхдагч зах зээлийн арилжаа болж хувьцааны бүртгэлийн 1-р ангилалд бүртгэгдсэн.
- 2017 оны байдлаар 216 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй болж Хөрөнгийн биржийн ТОП20 индекст багтсан.

### МИК-ийн онцлог


- “МИК ОССК” ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч орон сууц санхүүжилтийн компани бөгөөд Засгийн газрын орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн гол оролцогч юм.
- Буцаах нөхцөлтэй болон буцаахгүй нөхцөлөөр ипотекийн зээлийн хөрөнгийг ипотекийн зээлийн анхдагч зах зээлээс худалдан авснаар Монгол улсын орон сууцны зах зээл, санхүүгийн систем дахь чухал үүрэгтэй тоглогч болсон.






## 1.1 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

### “МИК Холдинг” ХК-ийн бүтэц



### “МИК ОССК” ХХК-ийн бүтэц

(МИК Холдинг ХК-ийн охин компани)



### “МИК Актив ТЗК” ХХК-ийн бүтэц

(МИК ОССК ХХК-ийн охин компани)

МИК Актив ТЗК ХХК (1-18)  
Төлөөлөн удирдах зөвлөл

МИК Актив ТЗК ХХК (1-16)

МИК Актив ХХК (17-18)



## 2. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### 2.1 Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

“МИК Холдинг” ХК нь 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дараах бүтэц, орон тоонд нийт 7 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

*“МИК Холдинг” ХК-ийн бүтэц дэх албан тушаал, ажилтны тоо:*

Албан тушаал	Ажилтны тоо
Гүйцэтгэх захирал	1
Дотоод аудитор	2
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	2
ТУЗ-ийн ажлын албаны хуульч	1
ТУЗ-ийн ажлын албаны зөвлөх	1
<b>НИЙТ</b>	<b>7</b>

Эдгээр удирдлага, албан тушаалтнууд “МИК Холдинг” ХК, “МИК ОССК” ХХК болон түүний охин компаниуд болох МИК Актив Нэг-Арван зургаа хүртэлх ТЗК-иудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах зорилгоор “МИК ОССК” ХХК-тай хамтран ажиллаж байна.

### 2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)

“МИК Холдинг” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) байна. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл болон компанийн Дүрмийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд жилд нэг удаа зарлан хуралдуулдаг. ХЭХ нь ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах, компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах болон Компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасан бусад асуудлыг тухай бүр хэлэлцэж шийдвэр гаргадаг.

### 2.3 Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)

Компанийн тухай хуульд заасан Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлаас бусад тохиолдолд компанийн удирдлага болон бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) хэрэгжүүлнэ. “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ нь компанийн засаглалын олон улсын жишигт нийцүүлэн Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэг, Компанийн Дүрэмд заасны дагуу 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн 6 ердийн гишүүн болон 3 хараат бус гишүүн сонгогдон ажиллаж байна.

#### 2.3.1 ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүн

**М.Мөнхбаатар** нь Улаанбаатар хотын банкны зөвлөх, 2018 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн даргаар улиран сонгогдсон. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны даргаар ажилладаг.



**Б.Ганбат** нь Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, ТУЗ-ийн ердийн гишүүнээр улиран сонгогдсон. ТУЗ-ийн дэргэдэх Үйл ажиллагаа, эрх зүйн хорооны дарга болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус сонгогдсон.

**Л.Гантөмөр** нь Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал, ТУЗ-ийн ердийн гишүүнээр улиран сонгогдсон. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга болон Санхүү, аудитын хорооны гишүүнээр тус тус сонгогдсон.

**Б.Чойжилжалбуу** нь Монгол Улсын Хөгжлийн банкны Актив, пассив, хөрөнгийн удирдлагын газрын захирлаар ажилладаг. ТУЗ-ийн ердийн гишүүнээр улиран сонгогдсон. ТУЗ-ийн дэргэдэх Үйл ажиллагаа, эрх зүйн хорооны гишүүнээр сонгогдсон.

**Т.Даваажав** нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдсон. Мөн ТУЗ-ийн дэргэдэх Үйл ажиллагаа, эрх зүйн хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус сонгогдсон.

**Б.Гантулга** нь “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдсон. ТУЗ-ийн дэргэдэх Үйл ажиллагаа, эрх зүйн хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус сонгогдсон.

**Ч.Хашчулуун** нь Монгол Улсын Их Сургуулийн Профессор, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр улиран сонгогдсон. ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хороо, Үйл ажиллагаа эрх зүйн хороо болон Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны гишүүнээр тус тус сонгогдсон.

**Э.Шижир** нь Уул уурхай металлургын цогцолбор байгуулах төслийн удирдагч, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр улиран сонгогдсон. ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хорооны дарга болон Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны гишүүнээр тус тус сонгогдсон.

**Ч.Отгочулуу** нь “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв”-ийн зөвлөх, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр улиран сонгогдсон. ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо болон Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны гишүүнээр тус тус сонгогдсон.

### 2.3.2 ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь ТУЗ-д хэлэлцэх асуудлуудад дүгнэлт өгдөг. “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн дэргэд Санхүү, аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Үйл ажиллагаа, эрх зүйн хороо, Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо гэсэн 4 байнгын хороо үйл ажиллагаа явуулж байна.

**Үйл ажиллагаа, эрх зүйн хороо** нь компанийн байгуулах аливаа гэрээ хэлцэл, үндсэн үйл ажиллагаатай холбоотой дотоодод дагаж мөрдөгдөх дүрэм, журмын төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, эрхлэх асуудлын хүрээнд бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулах, шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр хангах, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

**Эрсдэлийн удирдлагын хороо** нь эрсдэлийн бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хязгаарт хяналт тавих, бизнесийн үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлийг хянах, дүгнэлт гаргах, эрсдэлээс хамгаалах бодлого, журмыг хэрэгжүүлэхэд хяналт тавих, зөвлөмж, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

**Санхүү, аудитын хороо** нь ТУЗ-д удирдан ниглүүлэх болон хянан шалгах чиг үүргийг үр ашигтай, бүтээлчээр хийж гүйцэтгэхэд туслалцаа үзүүлэх, хөндлөнгийн аудитортой харилцан ажиллах, дотоод аудитын бодлогыг тодорхойлох, компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох



бүртгэл, санхүүгийн удирдлагатай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт өгөх, мэдээлэл, зөвлөмжөөр хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

**Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо** нь ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтанд тавигдах шаардлагыг тодорхойлох, нэр дэвшүүлэх, тэдгээрт олгох цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох болон компанийн удирдах албан тушаалтнуудын залгамж халааны бодлого, төлөвлөгөөний талаар дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

## 2.4 Гүйцэтгэх удирдлага

“МИК Холдинг” ХК-ийн 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлын шийдвэрээр Бадамхатан овогтой Гантулгыг Гүйцэтгэх захирлаар томилсон.

### *Гүйцэтгэх захирлын талаарх мэдээлэл:*

“МИК Холдинг” ХК болон “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлагнана. Мөн Гүйцэтгэх захирал өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах эрхийн хүрээнд дараах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн гүйцэтгэх захирлын хувиар компанийн болон бизнес хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлаар ТУЗ-д саналаа танилцуулж, чиглэл авч компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх;
- Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, хууль тогтоомжид заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тохиолдолд тухай бүрд нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний дагуу оролцох;
- Компанийн хөрөнгийн удирдлага, өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаанаас бусад компанийн хөрөнгө оруулалт, бусад эд хөрөнгө худалдах, худалдан авах зэрэг хэлцлийг ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хийх.

“МИК Холдинг” ХК болон “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга нь эдийн засагч мэргэжилтэй, 1997-2001 онд МУИС-ийн харьяа “Эдийн засгийн сургууль”-ийг санхүүч, эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөж, 2007-2008 онд Австрали улсын “Австралийн үндэсний их сургууль”-д санхүүгийн удирдлагаар магистрын зэрэг хамгаалсан. Төр, хувийн хэвшил, ОУВС-д ажиллаж байсан туршлагатай.

## 2.5 Компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл

№	Нэр	Албан тушаал	Иргэний харьяалал
1	Б.Гантулга	Гүйцэтгэх захирал	Монгол
2	Г.Саруул	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Монгол
3	Ц.Алтантуяа	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Монгол

### 3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

#### 3.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хурлын 2018 оны 18/17 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн 96.98 хувийн ирцтэйгээр хуралдаж, 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал, ТУЗ-ийн зардлын төсөв зэргийг хэлэлцэж баталсан. Мөн тус хуралдаанаар компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнийг сонгосон.

#### 3.2 Нөлөө бүхий Хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл

“МИК Холдинг” ХК нь 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 175 хувьцаа эзэмшигчтэй байна. Үүнээс компанийн нийт хувьцааны 19.3 хувийг төрийн өмчит байгууллагууд, 80.6 хувийг аж ахуй нэгж байгууллагууд, 0.1 хувийг иргэд эзэмшиж байна.

5 хувиас дээш хувьцаа эзэмшигчдийн нэрсийг дараах байдлаар харуулав. Үүнд:

№	Байгууллагын нэр	Эзэмшиж буй хувьцаа
1	Улаанбаатар хотын банк	26.1 %
2	“МИК ОССК” ХХК	19.98%
3	Монгол улсын хөгжлийн банк	14.9 %
4	Худалдаа хөгжлийн банк	9.9 %
5	Капитал банк	8.1 %
6	"Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК	7.5 %
7	Голомт банк	5.6 %

### 4. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хурлын 18/01 тоот тогтоолоор компанийн 2017 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

### 5. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“МИК Холдинг” ХК-ийн хөрөнгө оруулалттай “МИК ОССК” ХХК нь 2018 оны эхний хагас жилд “МИК Актив Арван дөрөв ТЗК” ХХК, “МИК Актив Арван тав ТЗК” ХХК-иудыг шинээр үүсгэн байгуулж, нийт 268.2 тэрбум төгрөгийн дүн бүхий ипотекийн зээлээр баталгаажсан бонд нэмж гаргасан бөгөөд мөн хугацаанд МИК Актив нэг-Актив арван дөрөв ТЗК ХХК-иас зөвхөн бонд эзэмшигчдэд 2018 оны эхний хагас жилийн байдлаар давуу эрхтэй бондын үндсэн төлбөрт нийт 118.6 тэрбум төгрөг, давуу болон энгийн бондын купоны төлбөрт 67.2 тэрбум төгрөгийг тус тус төлөөд байна.





**МИК ХОЛДИНГ ХК ГРУППИЙН 2018 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ  
БАЙДЛААРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

<b>ХӨРӨНГӨ</b>	сая төг
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	245,669.83
Дансны авлага	77.10
Хөрөнгө оруулалт	-
Бусад санхүүгийн хөрөнгө	2,689,367.35
Бусад санхүүгийн бус хөрөнгө	2,905.33
Үндсэн хөрөнгө	34,778.94
Биет бус хөрөнгө	82.03
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,972,880.57</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>	
Дансны өглөг	1,302.04
Татварын өр	686.82
Хүүний өглөг	20,429.34
Урьдчилж орсон орлого	2.59
Бусад богино хугацаат өр төлбөр	3,963.54
Богино хугацаат зээл	3,500.00
Урт хугацаат зээл	19,749.59
Бусад урт хугацаат өр төлбөр	2,729,984.99
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,779,618.92</b>
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>	
Хувьцаат өмч	20,709.32
Халаасны хувьцаа	(47,055.13)
Нэмж төлөгдсөн капитал	52,225.11
Хуримтлагдсан ашиг	136,624.04
Тайлант оны ашиг	30,758.31
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>193,261.65</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН:</b>	<b>2,972,880.57</b>
Хүүгийн орлого	115,627.42
Хүүгийн зардал	(68,821.34)
<b>ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО</b>	<b>46,806.08</b>
Хүүгийн бус орлого/зардал	(16,047.77)
Цэвэр ашиг	<b>30,758.31</b>
<p>Нийт активын хэмжээ 2017 оны 06-р сарын 30-ны байдлаар 2,972.8 тэрбум төгрөг хүрч, тайлант хугацаанд 115.6 тэрбум төгрөгийн орлого, 84.9 тэрбум төгрөгийн зардалтай ажилласнаар татварын дараах цэвэр ашгийг 30.7 тэрбум төгрөгт хүргэж ажилласан байна.</p>	
<b>Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд</b>	
<b>Ашиг ажиллагаа</b>	
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	2,1%
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	31,8%
<b>Өсөлтийн харьцаанууд</b>	



Нийт активын өсөлт  
Зээлийн багцын өсөлт  
Баталгаажсан бондын өсөлт

**Хөрөнгийн харьцааны үзүүлэлтүүд**

Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө

MIK HOLDING	
Хагас жилийн тайлан	
МИК ХОЛДИНГ ХК	7,1%
ХК	5,6%
	5,9%
11:6216038, и:5221978	
2525252525252525	
УЛААНБААТАР ХОТ	
	6,5%

Ипотекийн зээлээр баталгаажсан бондын хэмжээ нийт хөрөнгийн 91.8 хувийг, өөрийн хөрөнгийн хэмжээ 6.5 хувийг бүрдүүлж байна. Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 7.1 хувиар өсөхөд ИЗББ-ын хэлцлийн хэмжээ 5.9 хувиар өссөн нь нөлөөлсөн. 2018 оны 06-р сарын 30-ны байдлаар активын өгөөж 2.1%, өөрийн хөрөнгийн өгөөж 31.8% тус тус үзүүлэлттэй байна.